



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 459

Улаанбаатар хот

Төлбөрийн хэмжээг тооцох аргачлал  
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Хог хаягдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан “Хог хаягдлын норматив тогтоох аргачлал”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлын төлбөрийн хэмжээг тооцоолох, тусгай хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор Эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлын төлбөрийн хэмжээг тооцох аргачлалыг хавсралтаар баталсугай.

2. Төсвийн төлөвлөлт хийхдээ Эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлын төлбөрийн хэмжээг тооцох аргачлалыг баримтлан батлагдсан төсвийн дагуу зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

3. Эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлын төлбөрийн хэмжээг тооцох аргачлалын хэрэгжилтийг мэргэжил, арга зүйгээр ханган ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (О.Баяр)-т үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2011 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн “Эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлын төлбөрийн хэмжээг тооцох аргачлал батлах тухай” 93 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

081692

Эрүүл мэнд, спортын сайдын  
2015 оны 11 сарын 25 өдрийн  
159 дугаар тушаалын хавсралт



**Эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлын төлбөрийн  
хэмжээг тооцох аргачлал**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1. Энэхүү аргачлалыг эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлын төлбөрийн хэмжээ тооцоход ашиглана.
2. Эрүүл мэндийн байгууллагын албан тасалгаа, үйлчилгээний өрөө, агуулах, хонгил, орчны эдэлбэр газарт үүсэх ахуйн хог хаягдлын төлбөрийн хэмжээг тооцоход энэхүү аргачлал хамаарахгүй.
3. Энэхүү аргачлал нь эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлын хэмжээг тогтоож, менежментийг сайжруулах, төсөв, санхүү, хөрөнгө оруулалтыг зөв тодорхойлох, зөв төлөвлөх улмаар эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлыг бууруулахад чиглэгдэнэ.
4. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан “Хог хаягдлын норматив тогтоох аргачлал”-ын 4 дүгээр зүйлийн 2-д заасны дагуу Эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлын нормативыг орны фонд ашиглалт, үзлэг гэсэн нэгжээр тооцно.
5. Эрүүл мэндийн байгууллагаас гарах тусгай хог хаягдлыг тээвэрлэх, булах зардлыг тухайн орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр зохицуулна.
6. Эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлын төлбөрийн хэмжээг тооцох аргачлалд шаардлагатай тохиолдолд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

**Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт**

2.1. “Тусгай хог хаягдлын норматив тогтоох аргачлал” гэж эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлын төлбөрийг тооцох үйл ажиллагаанд мөрдөх баримт бичгийг;

2.2. “Эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдал” гэж оношилгоо, эмчилгээ, үйлчилгээний явцад үүсэх хүн, амьтны бие, эрхтэн, эд, хэсэг, бичил биетийн

өсгөвөр, цус, бусад шингэн, ялгадас, эм, эмийн бүтээгдэхүүн, нано бүтээгдэхүүн, био бэлдмэл, зүү, тариур, хурц үзүүртэй, иртэй багаж хэрэгсэл, ороох боох материал болон химийн, цацраг идэвхт бодисын үлдэгдэл зэрэг хог хаягдлыг;

2.3. “Тусгай хог хаягдлын төлбөр” гэж эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлын зардлыг;

2.4 “Тээврийн зардал” гэж эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлын түр хадгалах байрнаас эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг боловсруулах төв байгууламж хүртэлх зайг тооцоолсон өртөгийг;

2.5 “Тусгай хог хаягдлын устгал” гэж эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлыг халдваргүйтгэх, шатаах, булаах үйл ажиллагааг хэлнэ.

### **Гурав. Эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлын төлбөрийн хэмжээг тооцох**

3.1. Эрүүл мэндийн байгууллагуудын тусгай хог хаягдлын төлбөрийн хэмжээг эмнэлгийн ор, үзлэг тутамд Томъёо 1-ийг ашиглан тооцно.

$$Z = X + Y \quad [1]$$

**Z** – Эрүүл мэндийн байгууллагаас нэг жилд гарах тусгай хог хаягдлын нийт хэмжээ, кг

**X**- Эрүүл мэндийн байгууллагын хэвтэн эмчлүүлэгчээс нэг жилд гарах тусгай хог хаягдлын хэмжээ, кг

**Y** - Амбулаторийн үзлэгээс нэг жилд гарах тусгай хог хаягдлын хэмжээ, кг

Томъёо 1-д заасан хэмжигдэхүүний утга нь:

$$X = \text{Орны тоо} \times F \times \text{Орны фонд ашиглалтын хувь} \times 365 \text{ хоног}$$

$$Y = \text{Амбулаторийн үзлэгийн тоо} \times G$$

**F**-тухайн эрүүл мэндийн байгууллагаас хэвтэн эмчлүүлэх нэг ор тутмаас нэг өдөрт ялгарах тусгай хог хаягдлын хэмжээ, кг

**G**- тухайн эрүүл мэндийн байгууллагаас амбулаторийн нэг үзлэг тутамд ялгарах тусгай хог хаягдлын хэмжээ, кг

### **Дөрөв. Эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлын тээврийн зардлыг тооцох**

4.1. Эрүүл мэндийн байгууллагаас гарах тусгай хог хаягдлыг тээвэрлэх зардлыг Томъёо 2-аар тооцно.

$$Q = Z \times S \text{ /км/} \times Y \text{ төгрөг/кг/км} \quad [2]$$

- Q – Эрүүл мэндийн байгууллагаас ялгарах хог хаягдал тээвэрлэх зардал, төгрөг  
 Z – Эрүүл мэндийн байгууллагаас ялгарах хог хаягдлын нийт хэмжээ, кг  
 S – Эрүүл мэндийн байгууллагаас ялгарах хог хаягдлыг төвлөрсөн цэг хүртэлх зай, км  
 Y – 1 км-т 1 кг тусгай хог хаягдлыг тээвэрлэх зардал, төгрөг

**Тав. Эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлыг устгах үйл ажиллагааны зардлыг тооцоолох**

5.1. Эрүүл мэндийн байгууллагуудаас гарах тусгай хог хаягдлыг халдваргүйжүүлэх, шатаах зардлыг Томъёо 3-г ашиглан тооцно.

$$C = Z \times D \quad [3]$$

C – Эрүүл мэндийн байгууллагаас нэг жилд ялгарах тусгай хог хаягдлыг уураар халдваргүйжүүлэх, шатаах зардал

Z – Эрүүл мэндийн байгууллагаас нэг жилд гарах тусгай хог хаягдлын нийт хэмжээ, кг

D- 1 кг тусгай хог хаягдлыг уураар халдваргүйжүүлэх, шатаах зардал\*

(\*ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу 1 кг тусгай хог хаягдлыг уураар халдваргүйжүүлэх, шатаах зардлыг дараахь байдлаар тооцно.)

Хүснэгт 1.

Технологи	Хүчин чадал (кг/цаг)	Зардал (Төг/кг)
Уураар халдваргүйжүүлэх (автоклав)	23-3600	260-720
Шатаах	250-4000	300-600